Хөдөлмөрийн насны хүн ам гэж 15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна.

Ажиллах хүч гэж тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм.

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно. Ажиллах хүчнээс гадуурх хүн амаас боломжит ажиллах хүчийг тодорхойлно. Мөн ажиллах хүч болон боломжит ажиллах хүч хоёрын нийлбэрээр өргөтгөсөн ажиллах хүч илэрхийлэгдэнэ.

Ажиллагч гэж зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй хөдөлмөрийн насны хүнийг хэлнэ.

Хөдөлмөрийн дутуу ашиглалт гэж хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно. Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг дараах үзүүлэлтээр хэмжинэ. Үүнд:

1. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно. Босго цаг гэдгийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 40 цагаар авч үзнэ.
2. Ажилгүй хүн гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм.
    a. Хөдөлмөр эрхлээгүй гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн ажил хийгээгүй, ажиллагч гэдэг тодорхойлолтод хамаарахгүй байхыг;

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

б. Ажил хийхэд бэлэн гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт эсвэл тухайн хугацаанаас хойш ирэх хоёр долоо хоногт ажил хийж эхлэхэд бэлэн байхыг;

в. ажил хайж байгаа гэж сүүлийн дөрвөн долоо хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн хэлбэрээр ажил хайсан эсвэл хувийн бизнес эхлүүлэх оролдлого хийсэн хүн юм. Ажил хайх гэдгийг ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлэх, ажлын байрны талаар мэдээлэл авч ажил олгогчтой холбогдсон, ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих гэх мэт ажил олох оролдлого идэвхтэй хийхийг ойлгоно. Харин ажлын байрны талаар мэдээлэл авсан ч ажил олгогчид хандаагүй бол идэвхтэй оролдлого хийсэн гэж үзэхгүй.

3. Боломжит ажиллах хүч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм. Боломжит ажиллах хүчинд дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд:

   а. Ажил хийхэд бэлэн биш байгаа ажил хайгч буюу ажил хайх оролдлого хийж байсан ч тухайн хугацаанд ажил хийхэд бэлэн биш, боломжгүй байгаа хүн;

   б. Ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой хүн буюу ажил хайх оролдлого хийгээгүй ч ажил хийх хүсэлтэй, ажил хийхэд бэлэн байгаа хүн.

Бүртгэлтэй ажилгүй иргэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс болон хөдөлмөрийн биржид бүртгүүлсэн иргэдийг бүртгэлтэй ажилгүй иргэдэд хамруулна.

Төрийн албан хаагч гэж төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг ойлгоно.

Ажиллах хүч: Тухайн хугацаанд хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүний тооны нийлбэрээр тооцно. Ажиллах хүч = Ажиллагчид + Ажилгүй хүн

Өргөтгөсөн ажиллах хүч: Ажиллах хүч болон боломжит ажиллах хүчний тооны нийлбэрээр тооцно. Өргөтгөсөн ажиллах хүч = Ажиллах хүч + Боломжит ажиллах хүч

Ажиллах хүчний оролцооны түвшин: Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Ажиллах хүчний оролцооны түвшин} = \frac{\text{Ажиллах хүч}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} \times 100\%$$

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин: Ажиллагчдын тоог хөдөлмөрийн хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Хөдөлмөр эрхлэлтийн түвшин} = \frac{\text{Ажиллагчид}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} \times 100\%$$

Ажилгүйдлийн түвшин: Ажилгүй хүний тоог ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-1).

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

$$ХДАТ_1 = \frac{Ажилгүй\ хүн}{Ажиллах\ хүч} x\ 100\%$$

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин: Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид болон ажилгүй хүний тооны нийлбэрийг ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно.

$$ХДАТ_2 = \frac{Ажилгүй\ хүн+ЦХХББХЭ}{Ажиллах\ хүч} x\ 100\%$$

Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин: Боломжит ажиллах хүч болон ажилгүй хүний тооны нийлбэрийг өргөтгөсөн ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДА-3).

$$ХДАТ_3 = \frac{Ажилгүй\ хүн+боломжит\ ажиллах\ хүч}{Өргөтгөсөн\ ажиллах\ хүч} x\ 100\%$$

Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин: Хөдөлмөрийн дутуу ашиглалт буюу ажилгүй хүн, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч болон боломжит ажиллах хүчний тооны нийлбэрийг өргөтгөсөн ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-4).

$$ХДАТ_4 = \frac{Ажилгүй\ хүн + ЦХХББХЭ + БАХах\ хүч}{Өргөтгөсөн\ ажиллах\ хүч} x\ 100\%$$

ДУНДАЖ ЦАЛИН ХӨЛС

Дундаж цалин хөлс нь тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тоогоор жигнэсэн нийт цалин хөлс болон тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тооны харьцаа юм. Үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал, ажиллаагүй цагийн олговор болон бусад олговроос цалин хөлс бүрдэнэ.

$$\bar{x} = \frac{\sum_{i=1}^{n}(w_i * x_i)}{\sum_{i=1}^{n} w_i}$$

$\bar{x}$ - Дундаж цалин хөлс

x_i- Ажиллагчдын нийт цалин хөлс w_i- Ажиллагчдын тоо

Нэрлэсэн цалин нь хэрэглээний үнийн индексээр засварлагдаагүй, худалдан авах чадварын өөрчлөлтийг илэрхийлдэггүй бөгөөд татвар суутгал хасагдаагүй цалин, хөлс юм.

Нэрлэсэн цалингийн индекс нь тайлант болон суурь хугацаа (жил, улирлын)-ны нэрлэсэн дундаж цалин хөлсний хувиар илэрхийлсэн харьцаа байна.

$$Нэрлэсэн\ цалингийн\ индекс = \frac{Тайлант\ оны\ нэрлэсэн\ дундаж\ цалин}{Суурь\ оны\ нэрлэсэн\ дундаж\ цалин} x\ 100$$

Бодит цалин нь нэрлэсэн цалингийн хэрэглээний үнийн индексээр засварлагдсан, худалдан авах чадварын өөрчлөлтийг илэрхийлсэн үзүүлэлт юм.

Бодит цалингийн индексийг тооцохдоо нэрлэсэн цалингийн индексийг, хэрэглээний үнийн индекст харьцуулж 100-гаар үржүүлнэ.

$$Бодит\ цалингийн\ индекс = \frac{Нэрлэсэн\ цалингийн\ индекс}{Хэрэглээний\ үнийн\ индекс} x\ 100$$

Медиан цалин нь ажиллагчдын цалинг өсөх эрэмбээр байршуулсан цувааг таллан хуваах байгаа ажилтны цалин юм.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

Ажиллагчдын тоо тэгш тоо байвал:

$$M_e = \frac{n}{2} + 1$$

Хэрэв ажиллагчдын тоо сондгой тоо байвал:

$$M_e = \frac{n+1}{2}$$

M_e – Цувааны төвд орших ажилтны цалин
n – Нийт ажиллагчдын тоо

БҮТЭЭМЖ

Бүтээмж нь улс оронд бий болсон үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийн үзүүлэлт бөгөөд үйлдвэрлэл (гарц), үйлдвэрлэлийг явуулахад зарцуулсан орцын харьцаагаар тодорхойлно.

Бүтээмжийг тооцохдоо Үндэсний Статистикийн Хорооны даргын 2017 оны А/04 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан "Бүтээмж тооцох аргачлал"-ыг мөрдөж байна.

Хөдөлмөрийн бүтээмжийг (а) нэг ажиллагчид ногдох ДНБ-ий хэмжээ буюу хөдөлмөрийн бүтээмжийн түвшин, (б) ДНБ болон хөдөлмөрийн орц (ажиллагчдын тоо)-ын өөрчлөлтийн индексийн харьцаагаар тооцно.

Нэг ажиллагчид ногдох ДНБ-ийг улсын хэмжээгээр болон эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, харин хөдөлмөрийн бүтээмжийг зөвхөн бизнесийн секторын хувьд тооцно. Бизнесийн секторт төрийн удирдлага, батлан хамгаалах, боловсрол, эрүүл мэнд, үл хөдлөх хөрөнгө болон урлаг, үзвэр, тоглоом наадам, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарыг хамруулахгүй.

$$P = \frac{Q}{L}$$

P - хөдөлмөрийн бүтээмж
Q - дотоодын нийт бүтээгдэхүүн (нэмэгдэл өртөг)
L - ажиллагчдын тоо

ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААД ИРГЭД БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР ГАДААД УЛСАД ЗУУЧЛАГДСАН ИРГЭД

Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэн нь цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид болон төрийн бус байгууллага, олон улсын хүмүүнлэгийн байгууллага, шашны байгууллагад цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байгаа хүмүүс юм.

Гадаад иргэдэд ажил эрхлэх үйлчилгээг "Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах" тухай хууль, Засгийн газраас тухай бүр батлан гаргадаг гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахтай холбоотой тогтоол шийдвэрийн хүрээнд үзүүлдэг. "Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль"-ийн 15.1.4, 8, 9-р заалтын дагуу "HG", "O" болон "SH" ангиллын визээр гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээ болон уригч талын хөдөлмөрийн гэрээгээр ирсэн гадаадын иргэдэд ажил эрхлэх зөвшөөрөл олгож байна.

"HG" ангиллын визээр цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээгээр ирж ажиллана.

"SH" ангиллын визээр шашны байгууллагын урилгаар (i) цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид, (ii) цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байгаа гадаад иргэд хөдөлмөрийн гэрээгээр ирж ажиллана.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

“О” ангиллын визээр төрийн бус байгууллага, олон улсын хүмүүнлэгийн байгууллагын урилгаар цалин, хөлс, орлого олох зорилгоүйгээр сайн дурын ажил хийж байгаа гадаад иргэд хөдөлмөрийн гэрээгээр ирж ажиллана.

Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэн нь цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар зуучлагдсан хүмүүс юм.

Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын байгуулсан Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны хүрээнд БНСУ-д ажилтан илгээх болон хүлээн авах тухай “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн дагуу ажиллах хүч илгээж байна.

Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын оршин суух зөвшөөрөлтэй “Ур чадвартай” ажиллах хүчний тогтолцооны зохистой ажиллагааны үндсэн хүрээг хэрэгжүүлэх тухай хамтын ажиллагааны санамж бичгийн дагуу ажиллах хүч илгээж байна.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО (ҮОХХ)

Үйлдвэрлэлийн осол: гэж хөдөлмөр эрхлэгч иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөхийг ойлгоно.

Хурц хордлого: гэж цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг ойлгоно.

Осолдогч: гэж үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн ажилтан, иргэнийг ойлгоно.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн нэг ажилтан, иргэнийг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нэг тохиолдол гэж үзнэ. Хэрвээ нэг осол, хордлогод нэгээс дээш тооны хүн өртсөн бол осолдогч тус бүрээр үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол гэж тооцно.

Бүлэг осол, хурц хордлого: гэж нэг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод 2, түүнээс дээш тооны ажилтан, иргэн өртөхийг ойлгоно.

ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААН

Хөдөлмөрийн хамтын маргаан гэж хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, биелүүлэх, биелэлтэд нь хяналт тавих явцад гэрээ, хэлэлцээрт оролцогч талуудын хооронд үүссэн саналын зөрүүг ойлгоно.

Ажил хаялт гэж хөдөлмөрийн хамтын маргааныг шийдвэрлэх зорилгоор ажилтнаас үүрэгт ажлаа сайн дурын үндсэн дээр тодорхой хугацаагаар бүрэн буюу хэсэгчлэн түр зогсоохыг ойлгоно.

Ажил хаялтад оролцсон ажиллагчид: Ажил хаялтад шууд оролцсон ажиллагчид гэж ажлаа зогсоож ажил хаялтад шууд оролцсон ажиллагчдыг хэлнэ. Ажил хаялтад шууд бусаар оролцсон ажиллагчид гэж ажил хаялтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид байх бөгөөд ажлаа шууд зогсоож оролцоогүй боловч ажил хаялтын улмаас ажлаа үргэлжлүүлэх боломжгүй болсон бусад ажиллагчдыг хэлнэ.

$$\textit{1000 ажилтанд ногдох хөдөлмөрийн хамтын маргаанд хамрагдсан ажиллагчдын тоо} = \frac{\textit{Хөдөлмөрийн хамтын маргаанд хамрагдсан ажиллагчдын тоо}}{\textit{Нийт ажиллагчдын тоо}} \times 1000$$

METHODOLOGICAL NOTES

LABOUR FORCE

This chapter provides data on working age population, labour force, employed, unemployed and monthly average wage of employed. Basic data sources for estimates of these indicators are sample surveys and statistical reports relevant to labour statistics produced by the National Statistics Office such as reports on "Labour Force Survey (LFS)", "Survey on Wages and Salaries", "Monthly report of the registered unemployed", and "Statistical Overview of Civil Servant Structure and Movement" on an annual, quarterly and monthly basis.

Mongolia conducted the "Labour Force Survey" in 2002-2003 for the first time on a quarterly basis in accordance with international methodology. It was the national employment baseline survey that captured seasonal variations in the labour market. According to amendments to the Law on Statistics of Mongolia in 2004, the NSO has started to conduct Labour force survey on a quarterly basis and publishing the results since 2006.

"Revised methodology for Estimation of Labour Force Statistics Indicators" was approved by a Joint Resolution A-09/08 of 2019 of Chairperson of NSO Mongolia and the Minister of Labour and Social Protection and adopted since January 2019 for production of employment and labour force statistics and conducting sample surveys at the national level.

Definition:

Working-age population refers to population aged 15 years and older. Working-age population is classified into labour force and persons outside the labour force.

Labour force is defined as "the current supply of labour for the production of goods and services in exchange for pay or profit"; either as employed, or as unemployed persons.

Persons outside the labour force are those of working age who were neither in employment nor in unemployment in the short reference period for reasons of either being in education, retired, too old or disabled, or discouraged from seeking employment. This potential labour force is determined by the persons outside the labour force. Extended labour force is defined as the sum of the labour force and plus the potential labour force.

Persons in employment are defined as all those of working age who, during a short reference period, were engaged in any activity to produce goods or provide services for pay or profit.

Labour underutilization refers to mismatches between labour supply and demand, which translate into an unmet need for employment among the working age population. Measures of labour underutilization include, but may not be restricted to:

1. Persons in time-related underemployment are defined as all persons in employment who, during a short reference period, wanted to work additional hours, whose working time in all jobs was less than a specified hours threshold, and who were available to work additional hours given an opportunity for more work. The specified hours threshold is 40 hours per week, determined in line with the Mongolian labour law.
2. Persons in unemployment are defined as all those of working age who were not in employment, carried out activities to seek employment during a specified recent period and were currently available to take up employment given a job opportunity, where:
    a. Not in employment refers to someone who has not worked for pay or profit in a short reference period for measuring employment, such as the last week;
    b. Available to work refers to someone who was able to work during the same period used to assess employment, or in the following two weeks after that period;

METHODOLOGICAL NOTES

c. Seeking employment refers to any activity carried out, during a specified recent period comprising the last four weeks or one month, for the purpose of finding a job or setting up a business or agricultural undertaking. Seeking employment can be active attempts to get a job by registering with public or private recruitment offices, contacting to hiring personnel to get information on job vacancies, contacting to hiring personnel through email, put notice on media and publications.

3. Potential labour force refers to persons not in labour force who show some interest in being part of it, but for whom existing conditions limit their active job search and/or their availability. Potential labour force includes the following persons:

   a. Persons seeking employment but currently unavailable (unavailable jobseekers);

   b. Persons not seeking employment but wanted to be employed and currently available for employment (available potential jobseekers).

Registered unemployed are those segments of the population in the working age who are currently not involved in a paid or self-employed job, actively seeking work and registered at the labour divisions and labour exchange office according to the Law of Mongolia.

Government employee/Civil servants shall be the persons who are paid and ensured working conditions and guarantees by the state for holding a civil position and for exercising their powers.

Labour force: Sum of the employed who are supplying their labour to the labour market at the specified time and the unemployed who are available to supply their labour.

$$Labour\ force = Employment + Unemployed$$

Extended labour force: Sum of labour force and the potential labour force.

$$Extended\ labour\ force = Labour\ force + Potential\ labour\ force$$

Labour force participation rate (LFPR): Ratio of the labour force to the working age population, expressed in percentages.

$$Labour\ force\ participation\ rate = \frac{Labour\ force}{Working\ age\ population} \times 100\%$$

Employment-to-population ratio (EPR): Ratio of the number of employment to the working age population, expressed in percentages.

$$Employment\ to\ population\ ratio = \frac{Number\ of\ employment}{Working\ age\ population} \times 100\%$$

Unemployment rate: Ratio of the number of unemployed to the labour force, expressed in percentages.

$$LU_1 = \frac{Number\ of\ unemployed}{Number\ of\ labour\ force} \times 100\%$$

Combined rate of time-related underemployment and unemployment: Ratio of the sum of time related underemployment and the number of unemployed in the labour force.

$$LU_2 = \frac{Number\ of\ unemployed + TRUE}{Number\ of\ labour\ force} \times 100\%$$

Combined rate of unemployment and potential labour force: Ratio of the sum of potential labour force and the number of unemployed in the extended labour force.

METHODOLOGICAL NOTES

$$LU_3 = \frac{\text{Number of unemployed+Patential labour force}}{\text{Extended labour force}} \times 100\%$$

Composite measure of labour underutilization: Ratio of the sum of labour underutilization i.e. unemployed, time related underemployment and the number of potential labour force in the extended labour force.

$$LU_4 = \frac{\text{Labour underutilization}}{\text{Extended labour force}} \times 100\%$$

AVERAGE WAGES AND SALARIES

The average wages and salaries is a ratio of total wages and salaries weighted by the number of employees paid in the reference period to the number of employees paid in the reference period. Wages and salaries consist of basic pay, bonuses, compensation for hours of not working, and other payments.

$$\bar{x} = \frac{\sum_{i=1}^{n}(w_i * x_i)}{\sum_{i=1}^{n} w_i}$$

$\bar{x}$ - *Average wages and salaries*

x_i - *Total wages and salaries of employees*

w_i - *Number of employees*

The nominal wage is measured in terms of the monetary amount paid to employees before the deduction for taxes and contributions and is not adjusted by a consumer price index and does not represent changes in purchasing power.

The nominal wage index (NWI) is the ratio of the nominal wage of the current period to the nominal wage of a base period as an expressed percentage.

$$\text{Nominal wage index} = \frac{\text{Nominal wage for year of current}}{\text{Nominal wage for the base year}} \times 100$$

Real wages refer to wages that are adjusted by the consumer price index and reflect changes in purchasing power.

The real wage index is the ratio of nominal wage index and consumer price index.

$$\text{Real wage index} = \frac{\text{Nominal wage index}}{\text{Consumer price index}} \times 100$$

The median wage is the midpoint of the wage listed in ascending order.

If the number of employees an equal number:

$$M_e = \frac{n}{2} + 1$$

If the number of employees is an odd number:

$$M_e = \frac{n+1}{2}$$

M_e – *Employee salary at the center of the wage distribution*

n – Total number of employees

METHODOLOGICAL NOTES

LABOUR PRODUCTIVITY

Productivity is an indicator of effictiveness of production and service in the country, as measured in terms of the ratio of output and input of the production.

In the estimation of the productivity, "Methodology for Estimation of Productivity" approved by order No A/04 by the Chairman of the National Statistics Office in 2017 is being applied.

Labour productivity is defined as a ratio of (a) GDP per employee or labour productivity level and (b) indexes of changes in GDP and labour input (number of employees).

GDP per person employed is measured at the national level and by economic activities, while labour productivity is calculated only for the business sector. The business sector does not include public administration, defence, education, health, real estate, art, entertainment and recreation and other service sectors.

Labour productivity is gross domestic product (GDP) divided by total employment in the economy.

$$P = \frac{Q}{L}$$

P - labour productivity
Q - gross domestic product (value added)
L - total employment

FOREIGN WORKERS WITH LABOUR CONTRACT IN MONGOLIA AND EMPLOYEES WORKING ABROAD ON A CONTRACTUAL BASIS

Foreign workers with labour contract in Mongolia are persons in employment work for pay and profit and persons in volunteer work without pay and profit at non-governmental organizations, international humanitarian organizations and religious organizations.

Foreign workers are employed under the Mongolia Law on "Providing labour force to abroad and receiving labour force from abroad" and Government provisions related to receiving labour force from other countries. With contract to get labour force and specialist with "HG", "O" and "SH" visa under the provisions 15.1.4, 8, 9 of Mongolian Law on "Legal Status of Foreign citizen" and Labour contract of inviting party, work permission is provided to foreign citizens.

- Foreign workers with "HG" visa for purpose of earning pay and profit will be employed under the contract on employing labour force and specialist from abroad.

- Foreign workers or citizens with "SH" visa and an invitation of religious organization for purpose of (i) earning pay and profit or (ii) voluntary work without pay and profit will be employed under labour contract.

Foreign citizens with "O" visa and an invitation from non-government organization or international humanitarian organizations for purpose of voluntary work without earning pay and profit will be employed under labour contract.

A citizen recruited abroad on a contractual basis refers who is working on a contractual basis to earn pay and profit.

Within the framework of the Employment Permit System established between the Government of Mongolia and the Government of the Republic of Korea, labour is being sent to the Republic of Korea in according to the Memorandum of Understanding on sending and receiving employees.

The Government of Mongolia and the Government of Japan send manpower in according to the Memorandum of Understanding on the implementation of the framework for the proper functioning of the "Skilled" workforce system with a residence permit.

METHODOLOGICAL NOTES

OCCUPATIONAL ACCIDENTS AND ACUTE POISONINGS

Occupational accident: anunexpected hazards and other similar factors that occur to employed person during the course of implementing work and production.

Acute poisoning: short-term severe poisoning caused by exposure to active biological radiation and toxic chemical substances.

Injured person: a person affected by occupational accident and/or acute poisoning.

Single employed person: An employee or a citizen involved in an occupational accident or acute poisoning shall be considered as one case of an occupational accident or acute poisoning. If more than one person is involved in an accident or poisoning, each victim is considered as a case of an occupational accident or acute poisoning.

COLLECTIVE LABOUR DISPUTE

Collective labour dispute means a dispute involving the parties to a collective agreement or bargaining concerning the negotiation, enforcement, monitoring or supervision of such collective agreement or bargaining.

A strike means, in connection with a collective labour dispute, an action of employees whereby they voluntarily stop work, completely or partially, for a period of time.

Workers involved in a strike: Workers directly involved in a strike are those who participated directly by stopping their work. Workers indirectly involved in a strike are those employees of the establishments involved, or self-employed workers in the group involved, who did not participate directly by stopping their work but who were prevented from working because of the strike.

$$\text{The number of employees involved per 1000 workers} = \frac{\text{Number of employees involved}}{\text{Total number of employed}} \times 1000$$

Инфографик
Infographic

1 125.6 Ажиллагчид, мянган хүн
Employed, thousand persons

208.9 Монгол Улсын төрийн албан хаагчид, мянган хүн
Civil servants of Mongolia, thousand persons

177.3 Хөдөлмөрийн дутуу ашиглалт, мянган хүн
Labour underutilization, thousand persons

99.8 Ажилгүй хүн, мянга хүн
Unemployed, thousand persons

Ажиллах хүчний оролцооны түвшин
Labour force participation rate **56.9%**

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин
Employment to population ratio **52.3%**

Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин
Composite measure of labour underutilization **13.7%**

256 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого
Occupational accident, acute poisonings

9 Хөдөө аж ахуй *Agriculture*

101 Үйлдвэрлэл *Production*

146 Үйлчилгээ *Services*

1 Хөдөлмөрийн хамтын маргаан
Labour Dispute

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИД, цалин хөлсний бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2021 он
EMPLOYEES OF ESTABLISHMENTS, by group of wages and salaries, share to total, 2021



04 | ХӨДӨЛМӨР, ЦАЛИН
Labour and Wages

94 | Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт
бүс, аймаг, нийслэлээр

95 | Ажиллах хүч
бүс, аймаг, нийслэлээр

96 | Ажиллах хүчнээс гадуурх хүн ам
бүс, аймаг, нийслэлээр

97 | 15, түүнээс дээш насны ажиллагчид
бүс, аймаг, нийслэлээр | эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

99 | Хөдөлмөрийн дутуу ашиглалт
бүс, аймаг, нийслэлээр

101 | Ажилгүй хүн
хүйс, бүс, аймаг, нийслэлээр

103 | Ажиллах хүчний оролцооны түвшин
бүс, аймаг, нийслэлээр

104 | Хөдөлмөр эрхлэлтийн түвшин
бүс, аймаг, нийслэлээр

105 | Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин
бүс, аймаг, нийслэлээр

107 | Монгол Улсын төрийн албан хаагчид
бүс, аймаг, нийслэлээр төрийн албаны ангиллаар, захиргааны албан хаагчид, албан тушаалын ангиллаар

111 | Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд
улс орноор, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, аймаг нийслэлээр, оны эцэст

114 | Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин
бүс, аймаг, нийслэл | хүйсээр | ажиллагчдын тооны бүлгээр, хүйсээр | эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар | ажил мэргэжлийн ангиллаар, хүйсээр | байгууллагын хариуцлагын хэлбэрээр, хүйсээр | байгууллагын өмчийн хэлбэрээр

119 | Бодит цалингийн индекс
эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар | хүйсээр

122 | Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид
цалин хөлсний бүлгээр | дүнд эзлэх хувиар

124 | Нэг ажиллагчид ногдох ДНБ
эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр

127 | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого
бүс, аймаг, нийслэлээр, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

130 | Хөдөлмөрийн хамтын маргаан
бүс, аймаг, нийслэлээр

Employment indicators
by region, aimags and the Capital

Labour force
by region, aimags and the Capital

Persons outside the labour force
by region, aimags and the Capital

Employed aged 15 years and over
by region, aimags and the Capital | by classification of economic activity

Labour underutilization
by region, aimags and the Capital

Unemployed
by sex, region, aimags and the Capital

Labour force participation rate
by region, aimags and the Capital

Employment to population ratio
by region, aimags and the Capital

Rate of labour underutilization
by region, aimags and the Capital

Civil servants of Mongolia
by region, aimags and the Capital by the classification of civil service, general administration, by classification of positions

Foreign workers with labour contract
by countries, by classification of economic activity, by region, aimags and the Capital, at the end of the year

Monthly average wages and salaries of employees in establishments
by region, aimags, the Capital and sex | by employees size class and sex | by economic activity | by occupation and sex | by legal status and sex | by type of ownership

Real wage index
by economic activity | by sex

Employees in establishments
by group of wages and salaries | share to total

GDP per capita
by classification of economic activities , at 2015 constant prices

Occupational accidents and acute poisonings
by region, aimags and the Capital, by classification of economic activity

Collective labour dispute
by region, aimags and the Capital

4.1 ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ
EMPLOYMENT INDICATORS

Үзүүлэлт	*Indicators*	2017	2018	2019[1]	2020	2021
		мянган хүн / *thousand persons*				
Бүгд	***Total***					
Ажиллах хүч	*Labour force*	1 357.4	1 358.6	1 273.9	1 250.6	1 225.4
Ажиллагчид	*Employed*	1 238.3	1 253.0	1 146.2	1 162.9	1 125.6
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	*Time-related underemployment*	9.9	8.0	15.1	5.1	6.1
Ажилгүй хүн	*Unemployed*	119.1	105.6	127.7	87.7	99.8
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	*Persons outside the labour force*	863.0	868.0	832.2	877.5	926.8
Боломжит ажиллах хүч	*Potential labour force*	-	-	58.8	70.7	71.4
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	*Other outside the labour force, thousand persons*	-	-	773.4	806.8	855.4
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	*Labour force participation rate,%*	61.1	61.0	60.5	58.8	56.9
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	*Employment to population ratio,%*	55.8	56.3	54.4	54.6	52.3
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, %	*Composite measure of labour underutilization, %*	-	-	15.1	12.4	13.7
Ажилгүйдлийн түвшин, %	*Unemployment rate, %*	8.8	7.8	10.0	7.0	8.1
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, %	*Combined rate of time-related underemployment and unemployment, %*	-	-	11.2	7.4	8.6
Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, %	*Combined rate of unemployment and potential labour force, %*	-	-	14.0	12.0	13.2
Үүнээс: Эмэгтэй	***Of which: Female***					
Ажиллах хүч	*Labour force*	635.5	628.0	591.8	590.7	577.4
Ажиллагчид	*Employed*	585.7	583.4	539.3	551.1	532.8
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	*Time-related underemployment*	4.3	3.4	8.2	2.1	2.9
Ажилгүй хүн	*Unemployed*	49.8	44.7	52.5	39.6	44.6
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	*Persons outside the labour force*	515.1	547.3	516.1	549.4	580.2
Боломжит ажиллах хүч	*Potential labour force*	-	-	31.2	37.9	36.4
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	*Other outside the labour force, thousand persons*	-	-	485.0	511.5	543.8
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	*Labour force participation rate,%*	55.2	53.4	53.4	51.8	49.9
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	*Employment to population ratio,%*	50.9	49.6	48.7	48.3	46.0
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, %	*Composite measure of labour underutilization, %*	-	-	14.8	12.7	13.7
Ажилгүйдлийн түвшин, %	*Unemployment rate, %*	7.8	7.1	8.9	6.7	7.7
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, %	*Combined rate of time-related underemployment and unemployment, %*	-	-	10.3	7.1	8.2
Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, %	*Combined rate of unemployment and potential labour force, %*	-	-	13.4	12.3	13.2

Эх үүсвэр: Ажиллах хүчний судалгаа

1 Үндэсний Статистикийн Хорооны дарга, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын 2019 оны А-09/08 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлал"-ыг 2019 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөж байна.

Source: Labour force survey

1 The "New/updated methodology for estimating employment statistics" has been approved by the joint resolution A-09/08 from the Chairperson of NSO Mongolia and the Minister of Labour and Social Protection has been in force since January 2019.

4.2 АЖИЛЛАХ ХҮЧ, бүс, аймаг, нийслэлээр
LABOUR FORCE, by region, aimags and the Capital

Аймаг, нийслэл	*Aimags and the Capital*	2017		2018		2019[1]		2020		2021	
		Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*
		мянган хүн / *thousand persons*									
Бүгд	***Total***	**1 357.4**	**635.5**	**1 358.6**	**628.0**	**1 273.9**	**591.8**	**1 250.6**	**590.7**	**1 225.4**	**577.4**
Баруун бүс	***Western region***	**194.0**	**92.2**	**193.7**	**90.9**	**167.2**	**80.8**	**153.8**	**75.0**	**182.8**	**85.5**
Баян-Өлгий	*Bayan-Ulgii*	53.2	24.4	55.8	26.8	34.0	16.3	31.4	13.8	39.8	16.7
Говь-Алтай	*Govi-Altai*	28.3	14.0	28.6	13.3	27.1	13.6	23.4	12.9	23.9	11.9
Завхан	*Zavkhan*	34.6	16.9	33.3	16.2	30.8	15.2	31.0	15.0	29.8	13.8
Увс	*Uvs*	38.2	18.2	36.4	16.5	34.9	15.5	34.7	17.6	49.6	24.4
Ховд	*Khovd*	39.7	18.7	39.6	18.1	40.4	20.2	33.3	15.7	39.7	18.7
Хангайн бүс	***Khangai region***	**282.7**	**132.8**	**280.7**	**131.4**	**260.7**	**122.5**	**248.4**	**121.2**	**240.4**	**117.0**
Архангай	*Arkhangai*	45.2	21.8	46.3	21.6	49.9	21.3	41.9	21.1	39.4	19.8
Баянхонгор	*Bayankhongor*	43.3	20.4	44.7	20.9	36.0	17.6	43.9	21.6	34.4	19.8
Булган	*Bulgan*	30.8	14.0	29.5	14.1	29.9	15.3	24.6	12.4	24.8	11.4
Орхон	*Orkhon*	42.1	20.0	40.1	19.1	35.8	17.4	37.0	16.9	36.6	16.8
Өвөрхангай	*Uvurkhangai*	59.7	27.8	59.0	27.9	51.7	23.1	45.6	21.3	52.6	24.7
Хөвсгөл	*Khuvsgul*	61.6	28.8	61.1	27.8	57.4	27.8	55.4	27.9	52.6	24.5
Төвийн бүс	***Central region***	**234.4**	**110.7**	**234.2**	**110.9**	**218.0**	**102.6**	**199.6**	**95.4**	**187.6**	**87.2**
Говьсүмбэр	*Govisumber*	7.7	3.7	7.5	3.8	8.0	3.8	7.5	3.6	7.9	3.7
Дархан-Уул	*Darkhan-Uul*	42.5	19.6	39.2	17.7	42.8	20.5	37.8	18.1	33.5	15.8
Дорноговь	*Dornogovi*	33.4	16.1	31.3	14.6	33.0	15.6	29.3	14.2	28.4	12.9
Дундговь	*Dundgovi*	23.7	11.4	24.6	12.3	23.2	11.4	22.2	11.0	23.2	11.4
Өмнөговь	*Umnugovi*	30.3	14.6	32.0	15.2	32.5	15.5	30.2	14.6	29.3	13.2
Сэлэнгэ	*Selenge*	46.5	21.5	48.6	22.2	37.7	16.7	28.7	13.5	28.9	14.2
Төв	*Tuv*	50.3	23.8	51.0	25.1	40.8	19.1	43.9	20.4	36.4	16.0
Зүүн бүс	***Eastern region***	**92.7**	**42.1**	**94.7**	**43.0**	**98.5**	**45.3**	**96.7**	**44.3**	**97.7**	**46.5**
Дорнод	*Dornod*	31.5	14.2	32.2	13.3	33.5	15.1	34.6	16.3	31.8	15.7
Сүхбаатар	*Sukhbaatar*	29.3	14.4	29.3	14.1	30.6	13.8	29.0	13.5	28.8	13.4
Хэнтий	*Khentii*	31.9	13.5	33.2	15.6	34.4	16.4	33.1	14.5	37.1	17.4
Улаанбаатар	***Ulaanbaatar***	**553.6**	**257.7**	**555.3**	**251.8**	**529.5**	**240.6**	**552.1**	**254.8**	**516.9**	**241.2**

1 Үндэсний Статистикийн Хорооны дарга, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын 2019 оны А-09/08 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлал"-ыг 2019 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөж байна.

1 The "New/updated methodology for estimating employment statistics" has been approved by the joint resolution A-09/08 from the Chairperson of NSO Mongolia and the Minister of Labour and Social Protection has been in force since January 2019.

4.3 АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, бүс, аймаг, нийслэлээр
PERSONS OUTSIDE THE LABOUR FORCE, *by region, aimags and the Capital*

Аймаг, нийслэл	*Aimags and the Capital*	2017		2018		2019[1]		2020		2021	
		Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*
		хүн / *persons*									
Бүгд	***Total***	**862 988**	**515 060**	**867 959**	**547 274**	**832 183**	**516 148**	**877 503**	**549 429**	**926 788**	**580 246**
Баруун бүс	***Western region***	**70 333**	**41 705**	**74 075**	**44 650**	**94 764**	**53 415**	**106 664**	**60 913**	**111 555**	**64 933**
Баян-Өлгий	*Bayan-Ulgii*	21 143	12 220	23 854	13 619	43 726	22 422	50 145	26 697	44 699	25 006
Говь-Алтай	*Govi-Altai*	9 311	5 404	10 414	6 604	9 453	6 881	15 383	8 708	12 222	8 375
Завхан	*Zavkhan*	11 878	7 104	12 057	7 510	13 353	7 803	10 837	5 871	15 493	8 514
Увс	*Uvs*	11 801	6 751	13 731	8 234	16 225	7 867	14 270	8 677	19 324	10 991
Ховд	*Khovd*	16 200	10 226	14 019	8 683	12 007	8 442	16 029	10 960	19 817	12 047
Хангайн бүс	***Khangai region***	**117 006**	**69 309**	**126 586**	**77 563**	**126 780**	**75 275**	**128 141**	**75 760**	**133 032**	**86 815**
Архангай	*Arkhangai*	14 684	7 669	13 191	7 443	15 151	9 808	18 362	10 709	19 745	12 718
Баянхонгор	*Bayankhongor*	23 252	13 688	29 226	17 851	24 361	14 823	21 729	12 525	18 062	10 980
Булган	*Bulgan*	9 854	5 950	10 138	6 056	10 947	5 398	12 388	6 073	16 362	10 467
Орхон	*Orkhon*	23 496	14 508	22 351	13 895	27 492	16 377	23 476	14 559	24 548	16 326
Өвөрхангай	*Uvurkhangai*	17 746	10 277	20 423	13 073	23 593	13 233	25 067	14 728	24 579	16 787
Хөвсгөл	*Khuvsgul*	27 974	17 217	31 257	19 245	25 236	15 636	27 119	17 166	29 736	19 537
Төвийн бүс	***Central region***	**112 981**	**67 097**	**117 949**	**76 422**	**116 804**	**75 054**	**115 855**	**69 284**	**135 210**	**83 083**
Говьсүмбэр	*Govisumber*	3 455	2 230	5 016	3 343	2 738	1 500	3 562	2 295	3 760	2 261
Дархан-Уул	*Darkhan-Uul*	30 826	17 714	36 128	24 217	29 288	19 290	28 119	16 156	29 336	18 908
Дорноговь	*Dornogovi*	14 557	9 425	15 192	10 213	14 861	8 487	13 375	8 752	17 093	10 380
Дундговь	*Dundgovi*	6 812	4 208	6 289	4 332	7 814	5 518	9 371	5 881	9 261	5 826
Өмнөговь	*Umnugovi*	13 743	8 150	14 380	9 101	13 287	8 932	11 812	7 043	16 464	9 718
Сэлэнгэ	*Selenge*	30 688	17 668	27 292	16 658	29 516	17 452	31 549	18 061	38 103	21 503
Төв	*Tuv*	12 900	7 702	13 652	8 558	19 300	13 875	18 067	11 096	21 193	14 487
Зүүн бүс	***Eastern region***	**64 017**	**38 218**	**65 086**	**38 361**	**57 717**	**33 503**	**58 292**	**36 563**	**47 199**	**29 800**
Дорнод	*Dornod*	27 312	16 169	27 256	16 628	26 771	15 829	24 421	15 237	19 038	13 123
Сүхбаатар	*Sukhbaatar*	11 993	7 023	11 497	6 511	11 229	6 729	11 898	7 458	12 591	8 069
Хэнтий	*Khentii*	24 712	15 026	26 333	15 222	19 717	10 945	21 973	13 868	15 570	8 608
Улаанбаатар	***Ulaanbaatar***	**498 651**	**298 731**	**484 263**	**310 278**	**436 118**	**278 901**	**468 551**	**306 909**	**499 792**	**315 615**

1 Үндэсний Статистикийн Хорооны дарга, Хөдөлмөр, Нийгмийн Хамгаллын сайдын 2019 оны А-09/08 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлал"-ыг 2019 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөж байна.

1 The "New/updated methodology for estimating employment statistics" has been approved by the joint resolution A-09/08 from the Chairperson of NSO Mongolia and the Minister of Labour and Social Protection has been in force since January 2019.

4.4 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧИД, бүс, аймаг, нийслэлээр
EMPLOYED AGED 15 YEARS AND OVER, *by region, aimags and the Capital*

Аймаг, нийслэл	*Aimags and the Capital*	2017		2018		2019[1]		2020		2021	
		Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*
		мянган хүн / *thousand persons*									
Бүгд	***Total***	**1 238.3**	**585.7**	**1 253.0**	**583.4**	**1 146.2**	**539.3**	**1 162.9**	**551.1**	**1 125.6**	**532.8**
Баруун бүс	***Western region***	**173.1**	**81.0**	**176.5**	**81.7**	**147.7**	**70.7**	**138.3**	**67.7**	**166.9**	**76.3**
Баян-Өлгий	*Bayan-Ulgii*	46.6	20.5	48.7	22.0	25.8	11.8	24.9	10.8	34.3	13.6
Говь-Алтай	*Govi-Altai*	25.9	12.7	26.9	12.4	24.3	11.9	21.3	11.7	21.3	10.0
Завхан	*Zavkhan*	33.1	16.1	31.9	15.6	29.2	14.3	30.5	14.9	27.8	12.7
Увс	*Uvs*	33.2	15.5	32.7	15.0	32.6	14.2	30.8	15.1	47.5	23.5
Ховд	*Khovd*	34.3	16.2	36.3	16.7	35.8	18.5	30.8	15.2	36.0	16.5
Хангайн бүс	***Khangai region***	**254.9**	**120.9**	**260.7**	**121.5**	**239.4**	**113.4**	**232.2**	**113.0**	**220.2**	**107.0**
Архангай	*Arkhangai*	42.8	20.6	43.9	20.6	47.5	20.2	40.6	20.8	38.3	19.4
Баянхонгор	*Bayankhongor*	40.9	19.3	41.5	19.1	33.4	16.0	41.2	20.2	29.1	15.7
Булган	*Bulgan*	27.5	12.5	27.3	13.2	28.2	14.5	22.9	11.6	23.9	11.0
Орхон	*Orkhon*	32.2	15.6	34.9	16.0	31.6	15.9	34.4	15.4	31.0	14.1
Өвөрхангай	*Uvurkhangai*	55.2	26.1	55.9	26.4	48.5	21.6	42.6	20.0	50.6	23.8
Хөвсгөл	*Khuvsgul*	56.3	26.8	57.2	26.2	50.2	25.2	50.5	25.0	47.3	23.0
Төвийн бүс	***Central region***	**215.0**	**103.0**	**216.4**	**103.7**	**201.3**	**94.3**	**186.1**	**90.5**	**169.1**	**79.3**
Говьсүмбэр	*Govisumber*	7.1	3.4	6.6	3.2	7.3	3.4	6.8	3.3	6.9	3.3
Дархан-Уул	*Darkhan-Uul*	36.5	17.4	31.5	14.7	34.8	16.8	33.1	16.4	28.1	13.5
Дорноговь	*Dornogovi*	31.4	15.3	29.7	14.0	31.7	14.8	28.1	13.8	27.5	12.3
Дундговь	*Dundgovi*	22.6	11.1	23.3	11.7	22.0	10.5	21.5	10.6	22.0	11.0
Өмнөговь	*Umnugovi*	25.3	12.6	29.7	14.3	30.5	14.6	28.5	14.1	27.3	12.7
Сэлэнгэ	*Selenge*	43.5	19.9	45.9	21.1	35.9	16.1	25.5	12.2	21.7	10.8
Төв	*Tuv*	48.6	23.3	49.7	24.7	39.1	18.1	42.6	20.1	35.6	15.7
Зүүн бүс	***Eastern region***	**83.1**	**38.3**	**86.4**	**39.6**	**86.8**	**40.0**	**88.9**	**40.9**	**93.6**	**44.3**
Дорнод	*Dornod*	28.3	12.6	30.2	12.6	26.5	12.0	29.7	14.6	29.8	14.8
Сүхбаатар	*Sukhbaatar*	26.1	13.3	26.8	13.0	28.3	13.0	27.5	12.6	28.1	12.8
Хэнтий	*Khentii*	28.7	12.4	29.4	14.0	32.0	15.0	31.7	13.7	35.7	16.7
Улаанбаатар	***Ulaanbaatar***	**512.2**	**242.5**	**513.0**	**236.9**	**471.0**	**220.9**	**517.4**	**239.0**	**475.8**	**225.9**

1 Үндэсний Статистикийн Хорооны дарга, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын 2019 оны А-09/08 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлал"-ыг 2019 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөж байна.

1 The "New/updated methodology for estimating employment statistics" has been approved by the joint resolution A-09/08 from the Chairperson of NSO Mongolia and the Minister of Labour and Social Protection has been in force since January 2019.

4.5 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧИД, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар
EMPLOYED AGED 15 YEARS AND OVER, *by classification of economic activities*

Салбар	*Divisions*	2017		2018		2019[1]		2020		2021	
		Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*
		мянган хүн / *thousand persons*									
Бүгд	***Total***	**1 238.3**	**585.7**	**1 253.0**	**583.4**	**1 146.2**	**539.3**	**1 162.9**	**551.1**	**1 125.6**	**532.9**
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	*Agriculture, forestry, fishing and hunting*	356.4	153.6	334.1	143.5	290.2	126.3	276.5	122.3	291.7	126.6
Уул уурхай, олборлолт	*Mining and quarrying*	52.0	8.0	57.7	9.2	57.9	11.8	51.5	9.0	56.0	8.8
Боловсруулах үйлдвэрлэл	*Manufacturing*	93.1	43.4	100.8	49.4	90.4	47.3	89.7	44.6	84.7	42.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	*Electricity, gas, steam and air conditioning supply*	17.5	3.6	16.3	3.4	19.3	2.6	14.4	4.9	18.5	2.9
Усан хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	*Water supply; sewerage, waste management and remediation activities*	4.9	2.3	6.9	3.2	10.8	4.5	8.3	4.7	7.7	4.3
Барилга	*Construction*	70.6	13.4	76.6	13.4	68.8	11.9	77.3	11.3	82.2	17.6
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	*Wholesale and retail trade, repair of motor vehicles and motocycles*	204.5	121.6	211.2	119.4	160.4	90.8	166.6	82.6	149.2	81.8
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	*Transportation and storage*	72.7	11.3	73.6	11.3	61.1	8.3	66.6	14.0	57.8	9.6
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	*Accommodation and food service activities*	36.4	26.2	37.4	27.2	36.3	24.7	30.0	23.4	37.6	27.4
Мэдээлэл, холбоо	*Information and communication*	14.5	5.4	14.1	6.4	13.0	5.7	18.8	8.7	15.8	5.6
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	*Financial and insurance activities*	24.1	15.5	25.7	16.6	24.3	16.5	29.3	19.1	26.8	18.1
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	*Real estate activities*	0.4	0.3	0.8	0.2	1.2	0.4	3.4	2.2	2.0	1.2
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	*Professional, scientific and technical activities*	12.7	5.3	14.6	7.2	18.0	8.5	11.6	4.6	11.9	5.9
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	*Administrative and support service activities*	20.8	9.0	18.2	5.7	20.2	9.3	18.1	7.2	17.7	7.7
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	*Public administration and defence; compulsory social security*	82.2	36.4	76.2	31.0	86.0	32.7	83.4	38.7	85.6	38.1
Боловсрол	*Education*	98.9	75.5	98.7	73.8	96.1	70.5	110.7	81.0	99.1	79.4
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	*Human health and social work activities*	40.0	33.0	49.4	40.5	44.4	37.4	60.2	47.4	46.8	39.1
Урлаг, үзвэр, тоглоом наадам	*Arts, entertainment and recreation*	10.1	4.6	13.8	6.9	18.0	10.9	10.8	5.4	7.8	3.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	*Other service activities*	22.7	14.6	23.4	13.4	24.5	16.5	29.8	17.5	24.4	12.4
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	*Activities of households as employers*	2.3	1.7	1.2	0.6	3.3	1.4	3.3	1.7	2.0	0.9
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	*Activities of extraterritorial organizations and bodies*	1.5	1.0	2.3	1.1	2.0	1.3	2.6	0.8	0.3	0.3

1 Үндэсний Статистикийн Хорооны дарга, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын 2019 оны А-09/08 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлал"-ыг 2019 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөж байна.

1 The "New/updated methodology for estimating employment statistics" has been approved by the joint resolution A-09/08 from the Chairperson of NSO Mongolia and the Minister of Labour and Social Protection has been in force since January 2019.

4.6 ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ, бүс, аймаг, нийслэлээр
LABOUR UNDERUTILIZATION, *by region, aimags and the Capital*

Аймаг, нийслэл	*Aimags and the Capital*	Хөдөлмөрийн дутуу ашиглалт *Labour underutilization*		Ажилгүй хүн *Unemployed*		Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч *Time-related underemployment*		Боломжит ажиллах хүч *Potential labour force*	
		2019							
		Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*
		хүн / *persons*							
Бүгд	***Total***	**201 634**	**91 948**	**127 736**	**52 508**	**15 098**	**8 253**	**58 800**	**31 187**
Баруун бүс	***Western region***	**35 634**	**18 161**	**19 542**	**10 038**	**3 001**	**1 943**	**13 091**	**6 180**
Баян-Өлгий	*Bayan-Ulgii*	19 704	10 117	8 228	4 462	1 537	777	9 939	4 878
Говь-Алтай	*Govi-Altai*	3 440	1 751	2 902	1 594	94	30	444	127
Завхан	*Zavkhan*	3 401	2 099	1 535	939	661	479	1 205	681
Увс	*Uvs*	3 097	1 467	2 304	1 321	52	-	741	146
Ховд	*Khovd*	5 992	2 727	4 573	1 722	657	657	762	348
Хангайн бүс	***Khangai region***	**34 089**	**15 428**	**21 327**	**9 063**	**3 165**	**1 518**	**9 597**	**4 847**
Архангай	*Arkhangai*	5 168	2 388	2 372	1 084	1 952	722	844	582
Баянхонгор	*Bayankhongor*	4 213	2 098	2 615	1 535	-	-	1 598	563
Булган	*Bulgan*	3 404	1 280	1 713	784	372	152	1 319	344
Орхон	*Orkhon*	8 104	3 491	4 201	1 504	55	-	3 848	1 987
Өвөрхангай	*Uvurkhangai*	5 770	3 256	3 285	1 530	786	644	1 699	1 082
Хөвсгөл	*Khuvsgul*	7 430	2 915	7 141	2 626	-	-	289	289
Төвийн бүс	***Central region***	**26 098**	**13 322**	**16 625**	**8 318**	**1 671**	**512**	**7 802**	**4 492**
Говьсүмбэр	*Govisumber*	1 133	611	804	450	173	81	156	80
Дархан-Уул	*Darkhan-Uul*	11 296	5 485	8 014	3 673	512	170	2 770	1 642
Дорноговь	*Dornogovi*	2 066	1 209	1 272	807	361	-	433	402
Дундговь	*Dundgovi*	1 722	1 262	1 147	847	77	55	498	360
Өмнөговь	*Umnugovi*	2 535	1 220	1 957	942	-	-	578	278
Сэлэнгэ	*Selenge*	4 507	1 974	1 763	568	173	89	2 571	1 317
Төв	*Tuv*	2 839	1 561	1 668	1 031	375	117	796	413
Зүүн бүс	***Eastern region***	**16 773**	**8 438**	**11 773**	**5 393**	**1 604**	**1 095**	**3 396**	**1 950**
Дорнод	*Dornod*	9 046	4 571	6 995	3 094	331	331	1 720	1 146
Сүхбаатар	*Sukhbaatar*	4 045	1 788	2 323	859	881	497	841	432
Хэнтий	*Khentii*	3 682	2 079	2 455	1 440	392	267	835	372
Улаанбаатар	***Ulaanbaatar***	**89 040**	**36 599**	**58 469**	**19 696**	**5 657**	**3 185**	**24 914**	**13 718**

4.6.1 ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ, бүс, аймаг, нийслэлээр
LABOUR UNDERUTILIZATION, *by region, aimags and the Capital*

Аймаг, нийслэл	*Aimags and the Capital*	Хөдөлмөрийн дутуу ашиглалт *Labour underutilization*		Ажилгүй хүн *Unemployed*		Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч *Time-related underemployment*		Боломжит ажиллах хүч *Potential labour force*	
		2020							
		Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*	Бүгд *Total*	Эмэгтэй *Female*
		хүн / *persons*							
Бүгд	***Total***	**163 565**	**79 706**	**87 696**	**39 635**	**5 157**	**2 143**	**70 712**	**37 928**
Баруун бүс	***Western region***	**33 585**	**16 914**	**15 530**	**7 133**	**2 203**	**1 154**	**15 852**	**8 627**
Баян-Өлгий	*Bayan-Ulgii*	18 268	9 025	6 548	2 938	1 334	742	10 386	5 345
Говь-Алтай	*Govi-Altai*	3 586	1 993	2 155	1 113	-	-	1 431	880
Завхан	*Zavkhan*	1 882	770	497	107	490	354	895	309
Увс	*Uvs*	4 797	2 570	3 879	2 494	379	58	539	18
